



Хөндлөнгийн Боловсролын Үнэлгээний Удирдамж

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Боловсролын тухай хууль (IDEA)-ийн дагуу аливаа эцэг эх нь сурагчийн орон нутгийн боловсролын байгууллагаас (LEA)-аас авсан үнэлгээтэй санал нийлэхгүй бол сурагчид хөндлөнгийн боловсролын үнэлгээ (IEE)-г улсын зардлаар гаргуулан авах эрхтэй. IEE гэдэг нь тухайн сурагчийн боловсрол хариуцсан LEA -д ажилладаггүй, мэргэшсэн шинжээч хийсэн үнэлгээ юм. Эцэг эх нь LEA -с санал нийлээгүй үнэлгээ гаргасан тохиролдол бүрт зөвхөн нэг IEE-г улсын зардлаар авах эрхтэй.

IEE-ийн хүсэлтийг Арлингтоны Улсын Сургуулиудын (AUC) Тусгай Боловсролын Албаны Бодлого Хэрэгжилтийн Хяналтын мэргэжилтэнд colleen.koval@apsva.us имэйлээр эсвэл шуудангаар дараах хаягт илгээх ёстой: Arlington Public Schools, Office of Special Education, Compliance Specialist, 2110 Washington Blvd., 2nd Floor, Arlington, Virginia 22204.

IEE-ийн хүсэлтийг хүлээн авсны дараа АУС нь IEE-г хаанаас авч болох болон IEE-ийн холбогдох шалгууруудын талаарх мэдээллийг эцэг эхэд өгнө. АУС нь IEE-ийн хүсэлттэй холбоотой үйл явц горимын дагуу явагдаж буйг тодруулах сонсгол хийхээр хүсэлт гаргах эрхтэй.

Виржиниа мужийн Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Тусгай Боловсролын Хөтөлбөрийг Зохицуулах Журамд "... үнэлгээг хийх шалгуурууд нь, тухайлбал үнэлгээ хийх байршил, шинжээчийн мэргэшил зэрэг нь тухайн орон нутгийн боловсролын байгууллага үнэлгээг эхлүүлэхдээ хэрэглэдэг шалгууртай адил байх" гэж заасан бий.

Эдгээр дүрэм журамд нийцүүлэн АУС дараах шалгууруудыг тогтоосон байна. Үүнд:

I. Шинэжжчид нь заавал:

- A. Виржиниагийн Боловсролын Зөвлөлийн хүчинтэй лицензтэй байх, хэрэв Мэрилэнд эсвэл Вашингтон ДС дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг бол үүнтэй дүйх мэргэжлийн лицензтэй байх ; Эсвэл
- B. Виржиниагийн Эрүүл Мэндийн Мэргэжилтнүүд Хариуцсан Яамнаас олгосон тухайн шинжээч нь тус мужид мэргэжлээрээ ажиллахыг зөвшөөрсөн хүчин төгөлдөр лицензтэй байх, хэрэв Мэрилэнд эсвэл Вашингтон ДС дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг бол үүнтэй дүйх мэргэжлийн лицензтэй байх.
- C. Зохицуулагч байгууллагуудаас ямар нэгэн шийтгэл эдлээгүй байх, үүнд лиценз эзэмшдэг аливаа мужид лиценз түдгэлзүүлэх, шалгагдах, болон сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.
- D. Виржина мужийн Арлингтон хотод тавин бээрийн хүрээнд (радиус) үйл ажиллагаа явуулдаг байх.

Е. Гэмт хэрэгт ял шийтгүүлсэн эсэх тухай гэрээлэн гүйцэтгэгчийн гэрчилгээний өргөдлийг бөглөсөн байх.

II. Үнэлгээг явуулахдаа дараах стандарт, удирдамжийг баримтална. Үүнд:

- A. Шинжээч нь сурагчид үнэлгээ өгөхийн өмнө юуны өмнө АУС-ын журамд заасан дээрх I зүйлд тодорхойлсон шалгуурын биелэлтийг хангаж байгааг нотлох баримтыг үзүүлэх, үнэлгээ явуулахыг зөвшөөрсөн баталгааг АУС-с авсан байх ёстой.
- B. Үнэлгээг ажлын байр, сургуулийн байр юм уу бусад зохих ёсны албан орчинд хийнэ. Үнэлгээг бүхэлд нь АУС-ийн зөвшөөрсөн хувь хүн удирдан зохион байгуулах ёстой.
- C. Бүх үнэлгээг нэг бүрчлэн тусад нь явуулах ёстой.
- D. Урьдчилан төлөвлөж улмаар АУС-р батлагдсан үнэлгээний аргачлалаас бусад тохиолдолд зөвхөн хамгийн сүүлийн үеийн шалгалтын хувилбар, дүнгийн аргачлал зэргийг үнэлгээнд ашиглах ёстой.
- E. Бүх шалгалтыг тестийн гарын авлагад заасан зааврын дагуу явуулж, үнэлсэн байх ёстой.
- F. Шаталсан буюу кластераас бүрдсэн бүх шалгалт эсвэл дэд хэсгүүдийг гүйцэтгэх ёстой бөгөөд шаталсан буюу кластерт дүйх стандарт оноог хавсаргах ёстой.
- G. Шалгалтуудыг сонгохдоо санаа зовоож буй боловсролын талуудыг бүрэн амрахуйц байдлаар сонгоно.
- H. Бүх шалгалт нь арьс өнгө, соёлын хувьд ялгаварлан гадуурхахгүй байх ёстой бөгөөд тэдгээрийг ашиглах тодорхой зорилгод нь нийцүүлэн хянаж баталсан байх.
- I. Англи хэлний мэдлэг хязгаарлагдмал хүүхдийг үнэлэхэд хэрэглэгддэг үнэлгээний материал, журмыг сонгохдоо хүүхдийн англи хэлний чадварыг хэмжих бус харин хөгжлийн бэрхшээлтэй эсэх, тусгай боловсрол хэрэгцээ байгаа эсэхийг илрүүлэхэд чиглэсэн байх ёстой.
- J. Бүх үнэлгээг хүүхдийн төрөлх хэл дээр явуулах, хэрэв ийм боломжгүй бол бусад харилцааны хувилбар аргуудыг ашиглан явуулах.
- K. Шалгалтыг сонгож ашиглахдаа хүүхдийн сул хөгжсөн мэдрэхүй, хөдөлгөөний юм уу харилцааны бэрхшээлийг тусгах бус харин хүүхдийн бодит чадвар, амжилтын түвшин юм уу эсвэл тухайн шалгалтын анхны зорилго чиглэлийг нарийн зөв тусгахад чиглэсэн байх ёстой. Хэрэв авч буй шалгалт нь дээр дурьдсан хөгжлийн бэрхшээлийг үнэлэхэд чиглэсэн бол энэ шаардлага хамаарахгүй байж болно.
- L. Албан бус/эсвэл стандарт бус үнэлгээний арга хэрэгслийг албан ёсны үнэлгээнд нэмэлтээр ашиглаж болно.

III. Үнэлгээний тайланд дараах стандарт, удирдамжийг баримтална. Үүнд:

- A. Холбогдох зан төлөвийн ажиглалтыг тайланд тусгасан байх ёстой.
- B. Хэрэв үнэлгээг стандарт нөхцөлд хийгээгүй бол стандарт нөхцлөөс ялгагдах тодорхойлолтуудыг үнэлгээний тайланд оруулсан байх ёстой.

- C. Авсан шалгалтуудтай хамаарах бүх онооны хавсралтыг тайлантай хамт ирүүлсэн байх ёстой. Уг тайланд шалгалтуудыг соёл, хэл шинжлэлийн хүчин зүйлд үндэслэн сонгосон бөгөөд үр дүн нь хүчинтэйг бататгасан мэдэгдэл орсон байх ёстой.
- D. Шинжээч нь шалгалтын үр дүнг тайлагнахдаа объектив байх ёстой. Шинжээч нь тодорхой хөтөлбөр, анги хуваарилалт, тухайн хөтөлбөрт тэнцэх эсэх талаар тодорхой санал гаргахгүй байх, учир нь мужийн хуулиар эдгээр шийдвэрийг ажлын өргөтгөсөн хороо гаргах ёстой гэж заасан байдаг.
- E. Нэмэлт үнэлгээ хийх аливаа саналыг тухайн сургуулийн ажлын хэсэгт хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

IV. Дараах хураамж, зардал, шимтгэлийг АУС-аас тогтоосон байна. Үүнд:

Үнэлгээний төрөл	Хураамж
Сэтгэл судлалын	\$2500 хүртэл
Боловсролын	\$1500 хүртэл
Мэдрэл, сэтгэлзүйн	\$4000 хүртэл
Нийгэм-соёлын	\$600 хүртэл
Хэл яриа/хэл шинжлэлийн	\$950 хүртэл
Сэргээн засах эмчилгээ	\$850 хүртэл
Физик эмчилгээ	\$850 хүртэл
Мэргэжлийн зан төлөвийн үнэлгээ	\$2000 хүртэл
Хөгжлийн бэрхшээлийн үед туслах технологи	\$1200 хүртэл
Сонсгол судлал	\$400 хүртэл
Сонсголын үйл явц	\$1000 хүртэл
Харааны үзлэг	\$400 хүртэл
Бусад үзлэг, үнэлгээ	\$500 хүртэл

V. Төлбөрийн нэхэмжлэл ирүүлэх журам:

- A. Шинжээч нь эх гарын үсэг бүхий үнэлгээний тайлангийн хуулбаруудыг АУС-ийн Тусгай Боловсролын Бодлогын Хяналтын мэргэжилтэн **болон** эцэг эхэд **нэгэн зэрэг** илгээх ёстой. АУС-ийн Тусгай боловсролын Алба тухайн сурагчийн сургууль дээрх ажлын хэсэгт эх тайланг хүргүүлнэ.
- B. Үнэлгээний ажлын нэхэмжлэх, W-9 маягт, [APS Stars Vendor Application-ийг](#) АУС-ийн Тусгай Боловсролын Бодлого Хэрэгжилтийн Хяналтын мэргэжилтэнд colleen.koval@apsva.us имэйлээр эсвэл баталгаат шуудангаар дараах хаягт илгээнэ:

Arlington Public Schools
Office of Special Education
Compliance Specialist
2110 Washington Blvd., 2nd Floor
Arlington, Virginia 22204

Хэрэв энэхүү удирдамжтай холбоотой асуулт байгаа бол АУС-ийн Бага болон Дунд сургуулиудын Тусгай боловсрол хариуцсан захирал эсвэл Бодлого Хэрэгжилтийн Хяналтын мэргэжилтэнтэй (703) 228-6040 тоот утсаар холбогдоно уу.